

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

"Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын
2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайланийн аудит

Аудитын код: ГСАТАГ-2020/33/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Чойр хот
2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа
Утас: 70543156
Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Наранбаяр
Утас: 70543179
Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn
Аудитор: Б.Анхтуяа
Утас: 70543179
Цахим хаяг: ankhtuyab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БХБС ТӨБЗГ	Барилга, хот, байгуулалтын сайд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	10
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
Менежментийн захидал	11
3.1 хууль тогтоомжийн ТАЛААР	12
3.2 ЗАРДЛЫН ТАЛААР	13
3.3 ЗАРДЛЫН ТАЛААР	14
3.4 ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ТАЛААР	15
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	16
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	16
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	17
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	19
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө /өмчийн вөрчлөлтийн тайлан	21
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	22
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	24



**ГОВЬСУМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, З дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: govsumb@audit.gov.mn

ГОВЬСУМБЭР АЙМГИЙН ГАЗРЫН
ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ТӨСВИЙН
ЗАХИРАГЧ Б.ОТГОНЧИМЭГ ТАНАА

2020. 02. 05 № 10.
таний ны № -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Говьсүмбэр аймгийн "Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар"-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аudit хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Говьсүмбэр аймгийн "Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар"-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Говьсүмбэр аймгийн "Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар"-ын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус хэлтэст мөрдэж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланда тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



Аудитын тайлан

2.1. Оршил

"Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг "Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын төсвийн шууд захирагч Б.Отончимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланда үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандулахуйц асуудал, запруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу "Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийллээ.

"Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 16-наас 2020 оны 01 дүгээр сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Говьсүмбэр аймгийн Төрийн аудитын газрын аудитор Б.Анхтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

"Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/13 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалыар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

"Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Төр, орон нутгийн удирдлагаас хэрэгжүүлж буй бодлогын хүрээнд газрын харилцаа, барилга, хот байгуулалт, барилгын материалын үйлдвэрлэл, орон сууц, нийтийн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх замаар хүн амын аятухтай, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх"-д оршино.

"Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Газар эзэмшигч, өмчлөгч, ашиглагч, суурь судалгааг үнэн бодит гаргах, цахим хэлбэрт оруулах, бодит мэдээллээр ханганд, мэргэжлийн чиглэлээр эрх зүйн туслалцаа үзүүлэх
2. Аймгийн ерөнхий төлөвлөгөөний дагуу барилгажилт тохижилтын ажлыг мөрдүүлэх, барилгын материалын лабораторийн үйл ажиллагааг тогтмолжуулах, барилгын материалын чанаар, барилгын гүйцэтгэлд техник хяналтыг өндөр түвшинд тавих
3. Орон сууц, нийтийн аж ахуйн салбарыг хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийг хангуулах
4. Нутаг дэвсгэр дээрх газар, үл хөдлөх хөрөнгийг кадастрын бүртгэлээр баталгаажуулах, мэдээллийн сан, хувийн хэрэг, газрын бирж, үнийн мэдээ, үнэлгээ, төлбөр, татварын тогтолцоог сайжруулж хэрэглэгчийг баталгаат мэдээллээр хангах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн албаны тухай хууль түүний дагалдан гарсан журмууд
- Монгол улсын их хурлын 2019 оны 21 дүгээр тогтоол "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"
- Монгол ул
- Монгол улсын Засгийн газрын "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 24 дүгээр тогтоол
- Монгол улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Төрийн албан хаагчид шагнал олгох журам", 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулалт олгох журам"
- Монгол улсын Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолын "Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам"
- Монгол улсын Засгийн газрын 2019 оны 38 дугаар тогтоол "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"

2.5. Нягтлан бodoх бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материалыг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бodoх бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус "Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын мердэж байгаа Нягтлан бodoх бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бodoх бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

"Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар" нь санхүү, нягтлан бodoх бүртгэлийн үйл ажиллагаанд "Санхүүгийн тооцоолох" ХХК-ийн Acolous программ хангамжийг ашигладаг байна.

"Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар "Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 31 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 179,477.4 мянган төгрөгөөс тооцон 1,794.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 3,073.4 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 оны жилийн эцсийн орлого, үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцсонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

"Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15,453.5 мянган төгрөгөөр буюу 5.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Үрьдчилгаа	-	22,502.0	22,502.0
Бараа материал	42,259.3	45,133.7	2,874.4
Үндсэн хөрөнгө	127,872.7	137,900.9	10,027.3
Нийт хөрөнгө	170,132.0	205,536.6	35,404.6
Өр төлбөр	1,031.1	1,033.1	2.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	169,100.8	204,503.5	35,402.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	170,132.0	205,536.6	35,404.6

Авлага дансны үлдэгдэл ёссен нь тухайн онд автомашин худалдан авах тендер шалгаруулалт хүчингүй болсонтой холбоотой аймгийн нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэлтийн дансанд төвлөрүүлж, дараа онд зарцуулахаар 20,000.0 мянга, засварын

ажил гүйцэтгэх гэрзэ байгуулж, хөлсийг урьдчилж шилжүүлсэн 2,502.0 мянган төгрөгийн авлага үүссэнээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь үнэ төлбөргүй 2,303.9 мянга болон шилжүүлэн авсан 7,059.6 мянган төгрөгийн бараа материал нэмэгдсэнээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал илрээгүй байна. Оны эцэст худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгээгүй байна.

Бараа материалын дансанд төсвийн хөрөнгөөр 14,290.2 мянга, хандив тусламжаар 2,303.9 мянга, шилжүүлэн авсан 7,059.6 мянга, нийт 23,653.7 мянган төгрөгийн бараа материал хүлээн авсан ба 17,789.9 мянган төгрөгийг байгууллагын үйл ажиллагаанд зарцуулж, 2,989.3 мянган төгрөгийн бараа материалыг данснаас хасаж, оны эцэст 45,133.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь дээд шатны байгууллагаас үнэ төлбөргүй хөрөнгө 18,830.0 мянга, барилгын техник хяналтын орлогоос 9,779.1 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс акталж, данснаас хассан 44,062.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 2016 онд үүссэн 1,031.1 мянган төгрөг нь нийт өр төлбөрийн 99.8 хувийг эзэлж байна.

Бусад 2.0 мянган төгрөгийн өр нь тайлант онд ажиллагчидтай холбогдсон тооцоноос шалтгаалан үүссэн байна. 2016 онд үүссэн 1,031.1 мянган төгрөгийн өглөг нь эзэн холбогдогч нь тодорхойгүй, еглэгийг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Биет бус хөрөнгө болон Засгийн газрын оролцоо дансанд өөрчлөлт ороогүй байна.

Нягтлан бодох буртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны запруулга хийгдээгүй байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар "Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар" нь тайлант онд 31,500.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 34,352.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 109.1 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Барилгын техник хяналтын орлого	31,500.0	25,155.9	6,344.1	
Газрын хуульд заасан хэлбэрээр эзэмших, ашиглах, захиран зарцуулахтай холбогдон бий болох орлого	-	9,196.5	-9,196.5	
Нийт дүн	31,500.0	34,352.5	2,852.5	109.1

Орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь баталж ирүүлээгүйгээс ямар шалтгаанаар орлого давж биелснийг тодорхойлох боломжгүй, нийт дунгэрээ төлөвлөгөөнөөс давсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 71504 газрын зураглал, кадастр хетэлбөрт зориулан 220,024.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 205,938.3 мянган төгрөгийг урсгал зардалд, 6,073.8 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 8,012.6 мянган төгрөгийг тогтмол зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт 205,938.3 мянган төгрөгийн зардлыг тусгай зориулалтын шилжүүлэг төсвөөс, 14,086.4 мянган төгрөгийн зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 211,876.8 мянган төгрөг буюу 96.3 хувтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлаас 6,932.6 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардлаас 332.9 мянга, тогтмол зардлаас 714.4 мянга бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр зардлаас 164.8 мянган төгрөг тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайланд үндсэн санхүүжилт 220,024.7 мянга, нэмэлт санхүүжилт 85,325.8 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 9,196.5 мянга, нийт 342,740.5 мянган төгрөгийн орлогыг тайлагнасан байна.

Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн санхүүжилт 220,024.7 мянга, нэмэлт санхүүжилт 85,325.8 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 9,196.5 мянга, туслах үйл ажиллагааны орлого 275,694.9 мянга, нийт 590,241.9 мянган төгрөгийн орлогыг тайлагнасан байна.

Нэмэлт төсөв: Барилгын техник хяналтын орлогоос 85,325.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хяналтын зардалд 17,352.6 мянга, хөрөнгө бэлтгэсэн 7,799.1 мянга, дотоод, гадаад сургалтын зардалд 9,073.3 мянга, урсгал зардалд 5,944.9 мянга, орлогын төлөвлөгөөний төвлөрүүлэлт 25,155.9 мянга, автомашин худалдан авахад урьдчилгаа төвлөрүүлэлт 20,000.0 мянга, нийт 85,325.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 31 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 7 эрсдэл тодорхойлж нийт 38 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 26,614.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 2,502.0 мянган төгрөгийн алдааг запруулж, 2,946.1 мянган төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 19,866.2 мянган төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага хүргүүлж, алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 24,112.2 мянган төгрөгийн запруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 22,812.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

- Нийт 2,502.0 мянган төгрөгийн засварын ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, хөлсийг урьдчилж шилжүүлсэн боловч авлагаар тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.2, үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад запруулав.

- Нэхэмжлэхийн дүнгээс илүү шилжүүлсэн 25.0 мянга, хууль журмын үндэслэлгүй 3 ажилтанд шагнал урамшуулал, тусламж олгосон 1,684.2 мянга, нийт 1,709.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 1.7, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 3, үнэн зөв байх батlamж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль журмын үндэслэлгүй шагнал урамшуулал, тусlamж, ур чадварын нэмэгдэл олгосон ба нэхэмжлэхээс илүү шилжүүлсэн нийт 1,709,168.00 төгрөгийг холбогдох этгээдээр телүүлэхээр төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

3. Нийт 60.0 мянган төгрөгийн хоол унааны зардлыг томилолтын зардалтай давхцуулан олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5 дахь заалт, үнэн зөв байх батlamж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: хоол унааны зардлыг давхцуулан олгосон нийт 60,000.00 төгрөгийг холбогдох этгээдээр телүүлэхээр төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

4. Буруу халагдсан ажилтанд шүүхийн шийдвэрийн дагуу цалинг байгууллагаас нехен олгосон боловч шийдвэр гаргасан буруутай этгээдээс авахаар авлага үүсгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.2, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1, 103.2 дахь заалт болон үнэн зөв байх, иж бүрэн байх батlamж мэдэгдлийг хангагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Буруу халагдсан ажилтанд төсвөес олгосон нийт 1,176,920.00 төгрөгийг холбогдох этгээдээр телүүлэхээр төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

5. ЗГ-аас тогтоосон өдөрт явбал зохих км норм нормативыг зөрчсөн, жолоочийн тооцооны хуудсанд спидометрийн заалт бичээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолын 2, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал, үнэн зөв байх, иж бүрэн байх батlamж мэдэгдлийг хангагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бүрдэл дутуу анхан шатны баримтуудыг бүрдүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

6. БХБС-ын тушаал зөрчин нийт 17,072.4 мянган төгрөгийн техник хяналтын зардлыг зориулалт бусаар зарцуулсан, нийт 1,251.5 мянган төгрөгийн сургалтын зардлын анхан шатны баримтын бүрдэл дутуу буюу хамрагдсан хүний бүртгэл хийгдээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, үнэн зөв байх, иж бүрэн байх батlamж мэдэгдлийг хангагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бусаар зарцуулсан болон бүрдэл дутуу анхан шатны баримтуудын зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

7. Ур чадварын нэмэгдлийг 2 ажилтанд шалгуур үзүүлэлтгүй олгосон 1,393.2 мянга нийт 1,393.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 3, үнэн зөв байх батlamж мэдэгдлийг хангагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэж олгох, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

"Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын санхүүгийн үйл ажиллагаанд дараах асуудлыг нарийвчлан авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

1. Эх үүсвэр батлагдаагүй байхад автомашин худалдан авах тендер зарласан
2. Барилгын техник хяналтын зардлыг БХБС-ын тушаалаар баталсан зардлыг зөрчиж зориулалт бусаар зарцуулсан, хөрөнгө бэлтгэсэн, эрх бүхий дээд байгууллагын удирдлагаас сайдын баталсан тушаалыг зөрчсөн шийдвэрийг албан бичгээр ирүүлж, хяналтын зардлаас зарцуулж байна.
3. Мөн барилгын хяналтын зардлыг БХБС-ын тушаалаар зарцуулж байгаа боловч нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн зарцуулж байгаа нь Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан журамтай зөрчилдөж байна. Иймд барилгын техник хяналтын зардал нь нэмэлт орлого гэж үзэх эсэхийг тодорхой болгож шийдвэрлэх шаардлагатай байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

"Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар" нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 146 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 5,770.1 мянган төгрөгийн зөрчилд 1,500.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлснээс 1,500.0 мянган төгрөгийн 1 албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Нийт 4 зөвлөмж өгснөөс 4 зөвлөмжийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид "Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланда аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

"Зөрчилгүй" дүгнэлт

"Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар -ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материалын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидалыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидалын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь "Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайландаа тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайландаа шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдоор нь эрэмбэлэн үзүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3.1 ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТАЛААР

Илрүүлэлт

Хөдөлмөрийн дотоод журмыг үндэслэлгүй, хүчин төгөлдөр бус хууль журмыг баримталж боловсруулсан байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Зөвлөмж

Шинээр хэрэгжиж буй хууль тогтоомжуудын хүрээнд хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулж батлах

Хариуцах ажилтан

Төсвийн захирагч Б.Отгончимэг
Нягтлан бодогч Л.Туяа

Эрсдэл

Хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүйгээс Хүлээн зөвшөөрсөн төлбөрийн акт тогтоогдох

Төсвийн захирагчийн хариу

3.2 ЗАРДЛЫН ТАЛААР

Илрүүлэлт

Хууль журмын үндэслэлгүй шагнал урамшуулал, тэтгэмж, тусlamжийг хавтгайруулан олгосон байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Терийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 1.7 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Зөвлөмж

Хууль журмын дагуу батлагдсан төсвийн хүрээнд шагнал урамшуулал, тэтгэмж, тусlamжийг олгох

Хариуцах ажилтан

Төсвийн захирагч Б.Отгончимэг
Нягтлан бодогч Л.Туяа

Эрсдэл

Батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулах,
хавтгайруулах

Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрсөн

3.3 ЗАРДЛЫН ТАЛААР

Илрүүлэлт

Нэмэлт санхүүжилтийн зардлыг дансны ангилал зөрчиж гүйлгээ хийсэн байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, толилуулга ба тодруулга батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын 3.2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Зөвлөмж

Нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулах эрхийг дансны ангилал бүрээр нээлгэх

Хариуцах ажилтан

Төсвийн захирагч Б.Огтончимэг
Няглан бодогч Л.Туяа

Эрсдэл

Нэмэлт санхүүжилт дансаар хийгдсэн
зардлын гүйцэтгэл буруу тайлагнах

Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрсөн

3.4 ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ТАЛААР

Илрүүлэлт

54 нэр төрлийн элэгдлээрээ анхны өргөө нэхсөн боловч байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгөд ашиглалтын хугацаа болон дахин үнэлгээ хийгээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 2 дугаар зүйлийн 2.1, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Зөвлөмж

Анхны өргөө нэхсөн, чанар байдлаа алдаж, цаашид ашиглалтын шаардлага хангахгүй болсон үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, цаашид үйл ажиллагаанд ашиглагдах боломжтой үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, дахин үнэлгээ хийх

Хариуцах ажилтан

Төсвийн захирагч Б.Отгончимэг
Нягтлан бодогч Л.Туяа

Эрсдэл

Үндсэн хөрөнгийн шинж чанар алдагдах, үнэ цэнэгүй болох

Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрсөн

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	42,259,269.04	67,635,695.48
34	УРЬДЧИЛГАА	00.00	22,502,000.00
34200	Төсөвт байгууллага	00.00	20,000,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	00.00	2,502,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	42,259,269.04	45,133,695.48
351	Түүхий эд материал	34,055,112.45	34,326,700.86
35110	Тусгай зориулалттай материал	34,055,112.45	34,326,700.86
354	Хангамжийн материал	8,204,156.59	10,806,994.62
35410	Бичиг хэргийн материал	3,449,080.00	3,530,970.00
35420	Аж ахуйн материал	4,473,876.59	4,538,824.62
35470	Бусад хангамжийн материал	281,200.00	2,737,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	127,872,740.35	137,900,893.90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	127,872,740.35	137,900,893.90
392	Биет хөрөнгө	116,306,906.91	126,838,393.90
39201	Барилга, байгууламж, орон сууц	69,460,463.18	69,460,463.18
39202	Хуримтлагдсан элэгдэл	-917,821.70	-2,356,938.02
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	177,829,593.02	187,907,281.16
39206	Хуримтлагдсан элэгдэл	137,488,978.71	135,742,661.29
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,580,282.06	11,919,680.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,094,130.95	-6,036,931.18
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,000,000.00	2,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-62,499.99	-312,499.95
393	Биет бус хөрөнгө	11,565,833.44	11,062,500.00
39301	Програм хангамж	1,720,000.00	1,720,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-954,166.56	-1,457,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	10,800,000.00	10,800,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	170,132,009.39	205,536,589.38
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,031,135.05	1,033,114.06
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,031,135.05	1,033,114.06
413	Өглөг	1,031,135.05	1,033,114.06
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,031,135.05	1,033,114.06
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	169,100,874.34	204,503,475.33
51	Засгийн газрын хувь оролцоо	169,100,874.34	204,503,475.33
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	86,919,521.28	86,919,521.28
51101	Өмч: - төрийн	86,919,521.28	86,919,521.28
512	Хуримтлагдсан үр дүн	78,330,236.46	113,732,837.45

51210	Өмнөх үеийн үр дүн	78,330,236.46	78,330,236.46
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	35,402,600.99
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,851,116.60	3,851,116.60
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	170,132,009.39	205,536,589.38

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	217,602,903.53	342,740,541.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,283,119.53	30,330,408.00
120	Нийтлэг татварын бус орлого	13,283,119.53	30,330,408.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,283,119.53	30,330,408.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,194,155.00	9,196,508.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	21,133,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	39,345,784.00	106,471,833.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	164,974,000.00	205,938,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	28,882,849.00	85,325,833.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хурээнд бий болсон нэмэлт орлого	26,482,849.00	85,325,833.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	14,086,400.00
132001	Ургал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	14,086,400.00
1330	Төсвийн захирагчдаас	10,462,935.00	7,059,600.00
133003	Хөрөнгийн	10,462,935.00	7,059,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	223,172,733.77	307,337,940.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	223,172,733.77	307,337,940.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	189,150,574.76	258,312,592.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	113,800,450.97	148,099,999.51
210101	Үндсэн цалин	113,800,450.97	148,099,999.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,307,427.52	19,148,119.88
210201	Тэтгэврийн даатгал	9,703,557.52	13,046,836.60
210202	Тэтгэмжийн даатгал	1,180,496.00	1,675,719.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	913,676.00	1,181,857.50
210204	Ажилгүйдлийн даатгал	225,506.00	289,064.37
210205	Эрүүл мэндийн даатгал	2,284,192.00	2,954,641.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,260,184.00	7,298,222.73
210301	Гэрэл, цахилгаан	718,998.00	778,660.73
210302	Түлш, халаалт	2,654,180.00	2,949,562.00
210303	Цэвэр, бохир ус	442,006.00	525,000.00
210304	Байрны түрээс	3,445,000.00	3,045,000.00

2104	Хангамж, бараа материалын зардал	11,719,058.51	21,209,313.91
210401	Бичиг хэрэг	7,151,796.93	8,671,287.42
210402	Тээвэр, шатахуун	2,196,000.00	6,785,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	886,030.00	426,058.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,160,293.58	383,035.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	1,954,438.49
210408	Бараа материал акталсны зардал	324,938.00	2,989,295.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	580,950.00	3,564,000.00
210604	Урсгал засвар	580,950.00	3,564,000.00
2107	Томилолт, зочны зардал	824,800.00	1,728,300.00
210702	Дотоод албан томилолт	824,800.00	1,728,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,418,152.00	38,683,672.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,055,052.00	38,433,672.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,117,751.76	18,580,964.45
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,415,691.76	18,580,964.45
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,022,159.01	49,025,347.04
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,499,857.00	6,525,000.00
